



IX/2021

Тархаасан: 2021 оны 10 дугаар сарын 11




Хүнсний ногооны хураалт өмнөх оны мөн үеэс 9.5 хувиар буурсан байна

Ургац хураалтын явцын мэдээгээр улсын хэмжээнд 2021 оны 10 дугаар сарын 1-ний байдлаар 127.9 мянган тонн үр тариа, 122.0 мянган тонн төмс, 69.6 мянган тонн хүнсний ногоо, 63.1 мянган тонн таримал тэжээл хурааж, 480.7 мянган тонн хадлан, 12.3 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн байна.

Хураасан таримал тэжээл 11.9 мянган тонноор буюу 23.3 хувиар, бэлтгэсэн гар тэжээл 184.0 тонноор буюу 1.5 хувиар өсөж, харин хураасан төмс 83.9 мянган тонноор буюу 40.8 хувиар, хүнсний ногоо 7.3 мянган тонноор буюу 9.5 хувиар, үр тариа 2.5 мянган тонноор буюу 1.9 хувиар, бэлтгэсэн хадлан 27.4 мянган тонноор буюу 5.4 хувиар өмнөх оны мөн үеэс тус тус буурсан байна. Бэлтгэсэн хадлан буурахад 2021 оны 9 дугаар сард хур тунадасны нийлбэр 846.4 мм-т хүрч олон жилийн дунджаас 8.3 хувиар илүү байсан нь нөлөөлсөн байна.

Увс, Булган, Сэлэнгэ, Төв аймагт хураасан үр тарианы 9.1–28.0 хувийг, Баян-Өлгий, Дархан-Уул, Ховд, Сэлэнгэ, Төв аймагт нийт төмсний 3.2-54.6 хувийг, Хэнтий, Хөвсгөл, Ховд, Төв, Дархан-Уул, Сэлэнгэ аймагт хүнсний ногооны 2.9-28.9 хувийг тус тус хураасан байна.

ЗУРАГ 1. ХУРААСАН ҮР ТАРИА, ТӨМС, ХҮНСНИЙ НОГОО, БЭЛТГЭСЭН ӨВС ХАДЛАН, ГАР ТЭЖЭЭЛ, жил бүрийн 10 дугаар сарын 1-ний байдлаар, мянган тонн



Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны мэдээгээр энэ оны 10 дугаар сарын 1-ний байдлаар улсын хэмжээнд 278.4 мянган га талбайд уринш боловсруулалт хийсэн нь өмнөх оны мөн үеэс 48.8 мянган га буюу 14.9 хувиар буурчээ.

Ойлголт, тодорхойлолт

Тариалсан талбай

Хөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг хэлэх бөгөөд тухайн жилд үр суулгасан газрын нийт хэмжээгээр тодорхойлно.

Нийт хураасан ургац

Тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг таримал ургамлын хэмжээгээр тодорхойлогдоно.

Га-гийн ургац

Талбайн нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ юм. Га-гийн ургацыг тодорхойлохдоо нэг төрлийн ургамал тариалсан талбайгаас хураан авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулна.



Эх үүсвэр

Ургац хураалт, хадлан тэжээл, бэлтгэлийн мэдээ (А-ХАА-8)

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, уриншийн элдэншүүлгийн мэдээ (З-ХАА-1)

Ангилал, код

Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал

Мэдээлэл авах холбоос

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь

2021 оны 11 дүгээр сарын 17

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Х.Энхжавхлан
Утас: (976-51)-261565



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212